БАТЛАВ:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.ӨНӨРБАЯР

ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, АХМАДЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ДААЛГАВАР

1	Төсөл боловсруулах үндэслэл	-Хүүхэд, залуучууд, ахмад настан иргэдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэдний эрүүл мэндэд анхаарах, бие бялдар оюун ухааныг хөгжүүлэх, насан туршийн боловсрол олгох хөгжлийн төвийг байгуулах шаардлагатай байгаа хүсэлтүүд, -Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XI.1.1.14 д тусгагдсан
2	Барилга байгууламжийн байршил	Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 12 р хороо
3	Газар олгогдсон захирамж, шийдвэр	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны 06 сарын 29 ний А/339 тоот захирамж
3	Зориулалт, хүчин чадал	Газрын хэмжээ 500 м2, Нэг дор 200 хүн үйл ажиллагаа явуулах хүчин чадалтай
4	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	- Дулааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх, - Цахилгааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх, - Цэвэр бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх,
5	Галын аюулгүй байдлын нөхцөл	-Барилга байгууламжийн зураг төсөл галын аюулгүй норм /БНбД 21.02.02/ -Барилга байгууламжийн аюулгүй байдал /БНбД 21.02.02/ -Утаа мэдрэгч дохиололтой байх
6	Өрөө тасалгаа	<u>Барилгад байгууламжид зайлшгүй байх өрөө тасалгаа</u> - Номын сангийн зориулалттай өрөө - Амралт чөлөөт цаг өнгөрүүлэх өрөө - Цайны өрөө - Сургалтын зориулалттай танхим - Иог, бясалгал хийх зориулалт бүхий өрөө - Спорт заал - Үзвэр үйлчилгээний танхим - Албан ажлын өрөө - Ажилчдын өрөө - Гонх, коридор,шатны хонгил, ариун цэврийн өрөө, шүршүүр гэх мэт - Дээрх өрөөнүүдийн зохиолн байгуулалт, хэмжээнүүд нь БНбД сатандартыг хангасан байна.
7	Дараахь БНбД хангасан байна.	<u>Хууль тогтоомж</u> - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Газрын тухай хууль - Усны тухай хууль - Бусад холбогдох хуулиуд <u>Норм, норматив</u> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбд 30-01-04/ - Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар /УББ 11-202-00/ - Барилгын орчны тохижилтын ажил /БНбД 3.01.06-09/ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх - Бусад холбогдох норм, дүрмүүдийг баримтлана
8	Захиалагчийн нэр, хаяг, утас	Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нэгдсэн үндэстний гудамж-5, Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, 808 тоот, утас 266241

9	Барилгын үндсэн бүтээц, материал	Барилга нь 2 давхар Суурь: цутгамал төмөр бетон баганан суурьтай. Цэвдэг хөрсөнд барилга төлөвлөх 1-р зарчим болон бетоны ажлыг БНбД 83-4Б-01 Үндсэн бүтээц: Цутгамал төмөр бетон карказ. Цутгамал төмөр бетоны ажлыг БНбД 83-4Б-01 Хучилт: Цутгамал төмөр бетон Хана: Дүүргэлтийн блокон Дулаалга: Хөөсөн полистрол хавтангаар дулаалж, байгаль цаг уурын онцлогыг үндэслэн орчин үеийн дэвшилтэт технологоор төлөвлөх. Барилгын дулаан БНбД 31-02-03 Дотор хана: тоосгон өрөгт бүтээц Засал:Өрөөнүүдийн хана таазыг барилгын норм дүрэмд нийцсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан эко материал сонгон төлөвлөх Цонх: 3 давхар шилтэй хуванцар рамтай, MNS5830:2008, MNS 5802:2007 стандартуудыг хангасан Хаалга: Гадна хаалга нь дулаалгатай металл хаалга байх, дотор хаалга модон шинэ дэвшилтэт материал ашиглахаар төлөвлөх Бусад: Агааржуулалтын систем, галын дохиолол, интернэт кабель, камерын систем, утаа манан мэдрэгч зэргийг тооцоолон оновчтой төлөвлөсөн байх
10	Барилгын давхрын зохион байгуулалт	Нийт талбай 450-500 м2 Барилгын 1 давхарт байрлах Сургалт, спортын танхим- 1 ш Сургалтын танхим – 2 ш Иог, бясалгалын өрөө – 1 ш Номын сан, кофе шопын зориулалт бүхий өрөө- 1 ш Ариун цэврийн өрөө – 1ш Барилгын 2 давхарт байрлах Оффис өрөө – 2 ш Ариун цэврийн өрөө-1 ш Чийрэгжүүлэлт, дасгалын өрөө -1 ш
11	Архитиктур төлөвлөлтийн шаардлага	Гадна тохижилтыг орчны барилга байгууламжтай уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц, пандусыг стандарт /MNS 6056:2009,6055:2009/ болон норм дүрмийн дагуу төлөвлөх, гадна талбай гэрэлтүүлгийн шийдлийг тусгах Биокомбинат, Туул-Шувуун фабрик орчмыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг баримтлан авто зам болон явган зам талбай, ногоон байгууламжийн нэгдсэн төлөвлөлт хийх, барилгын фасадыг орчны барилгуудтай уялдуулан төлөвлөх

Хянасан: СХОХ-ийн дарга Д.Батсүх

Боловсруулсан: Мэргэжилтэн Т.Итгэлмаа